



Г "Трoв интeрнeт" Г
АИЗБ-г

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР

210646 Улаанбаатар хот, Төрийн ордон,
Сүхбаатарын талбай 6, Утас: 26-30-83, Факс: 32-10-54
E-mail: Office@president.mn

2009. 08. 10 № 11/274
танай _____-ны № _____-т

Г Санал ирүүлэхийг хүсэх тухай Г

УИХ-ын 2009 оны намрын чуулганаар Монгол Улсын Ерөнхийлөгч "Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль"-ийн шинэчилсэн найруулга, "Хэвлэл мэдээллийн байгууллагын тухай хууль"-ийн төслийг өргөн барьж хэлэлцүүлэхээр төлөвлөж байна. Эдгээр хуулийн төслийг боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд хуулийн төсөлд тусгуулах зарчмын зарим байр суурийг нэгтгэхэд мэргэжлийн байгууллагын саналыг авахын тулд Та бүхэнд үүгээр хандаж байна.

Танай байгууллага дээрх хуулиудад дор дурдсан зарчмуудыг тусган оруулах явдлыг дэмжиж байгаа эсэх, эсхүл тодорхой шалтгаанаар санал нийлэхгүй байгаа эсэх, эсхүл нэмэлт саналтай байгаа эсэхээ 2009 оны 08 дугаар сард багтаан бичгээр ирүүлж туслана уу. Үүнд:

1. Шүүхээр гэм буруутай нь тогтоогдоогүй хүнийг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр зарлахдаа түүнийг гэмт хэрэгтэн мэтээр үзүүлэх буюу гэмт хэрэгтэн хэмээн ойлгогдох нэр томъёо хэрэглэхгүй байх;
2. Цагдаагийн байгууллага хэрэг илрүүлсэн талаараа хэвлэлийн мэдээлэл өгөхдөө гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа буюу эсвэл хэрэг нь нотлогдсон этгээдийг телевизийн дуран руу харахыг шаардах, нэрээ хэлэхийг тулгах зэргээр хүний эрхэмсэг байдал руу халдахгүй байх;
3. Гэмт хэргийн сэжигтэн, гэрч, хохирогч, шүүгдэгчийг цагдаа, хуулийн ажилтан байцаасан шинжтэй сурвалжлага, нэвтрүүлгийн үед тухайн хүнд нэр нүүрээ нууцлах бололцоо олгож, түүний өмгөөлөгчийг заавал байлцуулах;
4. Өршөөлөөр болон ял эдэлж дуусаад чөлөөлөгдөж байгаа хүний ялыг асуух, нэрээ хэлэхийг тулган шаардах зэргээр асуугдаж буй хүнийг нийгмээс тусгаарлахад чиглэсэн дайралт хийх, хүнийг гутаан ичээж, дорд үзэгдэх байдалд оруулахгүй байх;
5. Хэн нэгэн хүний үйлдсэн буюу үйлдсэн хэмээн сэжиглэгдэж буй хэргийн талаар мэдээлэл нийтлэхдээ тухайн хүний ах дүү, төрөл төрөгсөд, хамт олон, ижил шашинтан, ижил нас, хүйс, арьс өнгө, бэлгийн чиг баримжаатай хүмүүс, ястан үндэстэнд халдахгүй байх;
6. Гэмт хэрэгт уриалан дуудсан, хүнийг гутаан доромжилсон шинжтэй мэдээлэл теле-чат, онлайн сэтгэгдэл хэлбэрээр орж ирэхээс хамгаалах, эсвэл түүнийг дэлгэцээс даруй хасах техник, редакцийн чадвартай байх;

0104654

7. Хэвлэл мэдээлэл ашиглан хүнийг өөрийнхөө болон гэр бүлийнхээ эсрэг мэдүүлэг өгөхийг шаардахгүй байх;
8. Хүүхдийг хэргийн гэрч хохирогч, сэжигтнээр хэвлэлээр байцаахгүй байх;
9. Хүүхдийг гэмт хэргийн талаархи мэдээлэлд эх сурвалж болгон ашиглахгүй байх.

Эдгээр зарчмыг хуулийн үг үсэг болгон найруулаагүй байгаа бөгөөд энэхүү захидлаар зөвхөн урьдчилсан санал авч байгаа юм. Иймд саналаа чөлөөтэй хуваалцана гэдэгт итгэж байна.

Энэхүү албан бичгийг хүргүүлж буй байгууллагын жагсаалтыг хавсралтаар хүргүүлэв.



ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ХҮНИЙ ЭРХ,
ИРГЭНИЙ ОРОЛЦООНЫ БОДЛОГЫН
ЗӨВЛӨХ

Ц.Оюунгэрэл

Ц.ОЮУНГЭРЭЛ